

# СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ БОЛОН ЧУХАЛ АШИГТ МАЛТМАЛЫН ЭРГЭЛТ ДЭХ ХҮНИЙ ЭРХ

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨХЦӨЛД ХҮНИЙ  
ЭРХИЙГ ДЭМЖИХ, ХАМГААЛАХ АСУУДЛААРХ НҮБ-ЫН  
ТУСГАЙ ИЛТГЭГЧИД ХҮРГҮҮЛЭХ МЭДЭЭЛЭЛ



ЭМНЕСТИ  
ИНТЕРНЭШНЛ



# АГУУЛГА

1.	<u>ТАНИЛЦУУЛГА</u>	3
2.	<u>ЧУХАЛ АШИГТ МАЛТМАЛЫН ЭРГЭЛТ ДЭХ ХҮНИЙ ЭРХИЙН НӨЛӨӨЛӨЛ БА СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛД ХЭН ХАМГИЙН ИХЭЭР ӨРТӨХ ВЭ? ЯАГААД?</u>	3
3.	<u>СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ, ЧУХАЛ АШИГТ МАЛТМАЛЫН БҮРЭН ЭРГЭЛТ ДЭХ САНХҮҮ, ЧАДАВХ, ТЕХНОЛОГИЙН ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАЛТАД ХЭРХЭН ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ ВЭ?</u>	9

Эмнести Интернэшнл Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд хүний эрхийг дэмжих, хамгаалах асуудлаарх НҮБ-ын Тусгай Илтгэгчийн гаргасан чухал ашиг малтмалын олборлолт, дахин ашиглалт зэрэг сэргээгдэх эрчим хүчний хөгжлийн явц дах хүний эрхийн эерэг болон сөрөг нөлөөллийн талаар тайлагнах чухал ач холбогдолтой санаачилгыг дэмжин, сайшааж байна. Тусгай илтгэгчийн санал авах хүсэлтийн 2, 6, 7 дугаар асуултад илүүтэй төвлөрч энэхүү санал, зөвлөмжийг хүргүүлж байгаадаа таатай байна.

# 1. ТАНИЛЦУУЛГА

Эмнести Интернэшнл Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд хүний эрхийг дэмжих, хамгаалах асуудлаарх НҮБ-ын Тусгай Илтгэгчийн гаргасан чухал ашиг малтмалын олборлолт, дахин ашиглалт зэрэг сэргээгдэх эрчим хүчний хөгжлийн хүний эрхийн эерэг болон сөрөг нөлөөллийн талаар тайлагнах чухал ач холбогдол бүхий санаачилгыг дэмжин талархан хүлээн авч байна.<sup>1</sup> Тусгай илтгэгчийн санал авах хүсэлтийн 2, 6, 7 дугаар асуултад төвлөрч энэхүү санал, зөвлөмжийг хүргүүлж байгаадаа таатай байна.

## 2. ЧУХАЛ АШИГТ МАЛТМАЛЫН ЭРГЭЛТ ДЭХ ХҮНИЙ ЭРХИЙН НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛД ХЭН ХАМГИЙН ИХЭЭР ӨРТӨХ ВЭ? ЯАГААД?

Уур амьсгалын өөрчлөлт нь өнөө болон ирээдүй үеийнхний иргэний, улс төрийн болон эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ эдэлж хэрэгжүүлэхэд заналхийлсээр байна. Сэргээгдэх эрчим хүч рүү шилжих санаачилгын талаарх дараах статистик мэдээлэл байна.<sup>2</sup>

- 2024 оны эцэс гэхэд сэргээгдэх эрчим хүчний салбарт хийгдэх хөрөнгө оруулалтыг 3 их наяд гаруй ам.долларт хүрнэ хэмээн тооцоолсон.<sup>3</sup>
- Чухал ашигт малтмалын эрэлт 2030 он гэхэд хоёр дахин, 2050 он гэхэд зургаа дахин нэмэгдэж, зах зээлийн нийт эргэлт 400 тэрбум ам.долларт хүрч, улмаар 2020 онд олборлосон нийт нүүрсний үнээс давна хэмээн тооцоолсон.<sup>4</sup>
- Чухал ашигт малтмалын олборлоход оруулсан хөрөнгө оруулалт 2021 онд 20%-аар, 2022 онд 30%-аар тус тус өссөн.<sup>5</sup>
- Тэдгээр чухал ашигт малтмалын дотроос литийн хөрөнгө оруулалт хамгийн их буюу 50%-аар өссөн бол түүний дараа зэс, никель орж байна.<sup>6</sup>

Чулуужсан түлш олборлолт, үйлдвэрлэлт, ашиглалтаас үе шаттайгаар дэлхий даяар татгалзах нь яаралтай, зайлшгүй бөгөөд хэрэгжих шаардлагатай амлалт юм. Гэхдээ эрчим хүчний шилжилт хэрхэн явагдах нь чухалчлах асуудал байсаар байна.

Эрчим хүчний шилжилт нь тээврийн хэрэгслийг цэнэглэх, салхин сэнсийг ажиллуулах, нарны эрчим хүчийг хуримтлуулахад зориулан асар их хэмжээний ашигт малтмал шаарддаг. Тэдгээр ашигт малтмалын түүхий эд нь дэлхийн хөрс,

<sup>1</sup> <https://www.ohchr.org/en/calls-for-input/2025/call-inputs-human-rights-life-cycle-renewable-energy-and-critical-minerals>

<sup>2</sup> Renewables include electric vehicles, solar panels, wind turbines, and battery storage units, and improved electricity grids.

<sup>3</sup> IEA (2024), World Energy Investment 2024, IEA, Paris <https://www.iea.org/reports/world-energy-investment-2024>, Licence: CC BY 4.0

<sup>4</sup> IEA (2023), Critical Minerals Market Review 2023, IEA, Paris <https://www.iea.org/reports/critical-minerals-market-review-2023>, Licence: CC BY 4.0

<sup>5</sup> Ibid

<sup>6</sup> Ibid.

чулуулагт түгжигдэн агуулагддаг бөгөөд улс орнууд эдгээр нөөц баялгийн асран хамгаалагч болдог. Эдгээр ашигт малтмалыг олборлохыг зөвшөөрөх улс орнуудын шийдвэр нь уурхай, боловсруулах байгууламжийн ойр орчмын оршин суугчид болоод орон нутгийн байгаль орчинд үе дамжсан нөлөө үзүүлдэг. Ашигт малтмалын гэрээ нь улс орнуудыг хүний эрх, байгаль орчинд ихээхэн хохирол учруулдаг, хариуцлагаас мултарчихдаг дэлхийн уул уурхайн салбартай холбож, тэднийг үндэстэн дамнасан корпорацийн нөлөөнд өртөх эрсдэлд оруулдаг.<sup>7</sup>

Илүү үр ашигтай боловсруулалт, үйлдвэрлэлт нь оффшор бүсэд явагддаг энэхүү харилцааны хэлцлийн шинж нь байгалийн нөөцөөр баялаг улс орнуудыг өөрийн хүн амд урт хугацаанд ашиг тусаа өгөхгүй, хараат байдал, колонийн олборлолтын загварт орох эрсдэлд хүргэдэг. Эмнести Интернэшнл нь эрчим хүчний шилжилтэд шаардлагатай ашигт малтмалыг олборлох шинэ загварыг бий болгох чиглэлээр дараах кампанит ажил явуулдаг. Эмнести Интернэшнл болон бусад ТББ-уудын хийсэн судалгаагаар хүний эрхийн зөрчлийг зохистойгоор нөхөн сэргээж чаддаггүй аж үйлдвэр, уурхайн үйл ажиллагаа нь одоогийн байгаа эсхүл шинэ бүсүүдийг улам бүр гүнзгий эрсдэлд оруулж болохыг харуулж байна.

- Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсын ашигт малтмалаар баялаг Луалаба мужид амьдарч буй оршин суугчид хэдэн үеэрээ үйлдвэрийн зэс, кобальт олборлох уурхайн үйл ажиллагааны улмаас хүчээр нүүлгэн шилжүүлэгдэх, стандартын шаардлага хангаагүй орон сууц, хангалтгүй нөхөн олговор, эрүүл мэнд, байгаль орчинд учрах хохирол, ургац алдах, хүчирхийлэлд өртөх зэрэг асуудалтай нүүр тулж байна.<sup>8</sup> Уул уурхай эрчимжиж эхэлснээс хойш 10 жилийн хугацаанд эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн асуудал, арьсны тууралт, амьсгалын замын өвчлөл ихэссэн хэмээн Колвези хотын эмнэлгийн мэргэжилтнүүд мэдээлсэн. Аж үйлдвэрийн кобальт, зэсийн олборлолтын улмаас ус, агаар, хөрсний бохирдол их хэмжээгээр тархаж байгааг шинжлэх ухааны судалгаа харуулж байна.<sup>9</sup>
- Филиппинд никель олборлолт нь хүмүүсийн цэвэр, эрүүл, тогтвортой орчинд амьдрах эрхийг алдагдуулж, улмаар Палаван, Замбалесын орон нутгийн иргэдийн амьжиргаа, усны хүртээмж, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгааг мэдээлсээр байна. Палаваны уугуул иргэдийн хувьд компаниуд тэдний зан заншлын төлөөлөл болон шийдвэр гаргах үйл явцыг хүндэтгээгүй бөгөөд никель олборлолтын төслүүд нь тэднийг өвөг дээдсийнхээ нутаг дэвсгэрт нэвтрэхэд саад учруулж, тэдний соёл, өвөрмөц байдлыг нь сүйрүүлж байгааг мэдээлсэн.<sup>10</sup>

<sup>7</sup> Amnesty International, Injustice Incorporated: Advancing the right to remedy for corporate human rights abuses, POL 30/001/2014 pages 180-192

<sup>8</sup> Amnesty International, Initiative pour la Bonne Gouvernance et les droits humains, Powering Change or Business as Usual? Forced evictions at industrial cobalt and copper mines in the Democratic Republic of Congo, September 2023

<sup>9</sup> RAID UK, AirWatch, Beneath the green: a critical look at the environmental and human cost of industrial cobalt mining in the DRC, March 2024

<sup>10</sup> Amnesty International, What do we get in return? How the Philippines nickel boom harms human rights, 9 January 2025, ASA 35/8607/2024

- Канадын Бритиш Колумб дахь зэсийн уурхайн хаягдлын далангийн эвдрэл нь усны хагалбарт урт хугацаанд нөлөөлж байгаа хэдий ч тухайн үеийн ашигт малтмалын хууль тогтоомж нь байгаль орчныг бохирдуулагчийн төлбөр төлөх зарчмыг хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлээгүй байна. Зардлыг тооцохоос өмнө аюулгүй байдлыг шаардсан хууль тогтоомжгүй байхгүй нөхцөлд байгаль орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн шилдэг туршлага, технологид хөрөнгө оруулалт хийх сонирхол компаниудад хангалтгүй байна.<sup>11</sup> Гамшгийн хохирлыг хариуцах компани бохирдлыг цэвэршүүлэх үйл ажиллагааны зардлыг бүрэн төлөөгүй бөгөөд уурхайн хаягдлыг ойролцоох нуур руу цутгах зөвшөөрөл авсан нь оршин суугчдын эрүүл мэндэд урт хугацааны сөрөг нөлөөлөл учруулах вий гэж санаа зовниход хүргэж байна. Бритиш Коломбын татвар төлөгчдийн мөнгөөр бохирдол арилгах зардлын гуравны хоёрыг төлжээ.<sup>12</sup>
- Норвеги, Япон улс эдийн засгийн онцгой бүс нутагтаа далайн гүний олборлолт явуулах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд мөн тус улсуудын компаниуд Кларион Клиппертоны бүс зэрэг олон улсын далайд олборлолт хийх гэрээ байгуулахын тулд Олон улсын далайн ёроолын байгууллагад хүсэлт гаргаад байна.<sup>13</sup> Хэдийгээр далайн гүний олборлолтыг дэмжигчид өөрсдийн арга нь хуурай газрын олборлолтоос үүдэлтэй экологийн болон хүний эрхийн асуудлаас зайлсхийх боломжтой гэж үзэж байгаа боловч энэ нь одоогоор нотлогдоогүй байна. Далайн гүний экосистем бүрэн судлагдаагүй бөгөөд далайн гүний олборлолт нь эдгээр экосистем болон тэндээс хамааралтай амьдардаг хүмүүст хэрхэн нөлөөлөх нь тодорхойгүй хэвээр байна. Үүнээс гадна далайн гүний олборлолт нь загас агнуурын бүлгүүдийн амьжиргааны эрх, уугуул ард түмний хүнсний аюулгүй байдал, үе хоорондын шударга ёс, хүүхдийн цэвэр, эрүүл, тогтвортой орчинд амьдрах эрх зэрэг хүний эрхийн бусад асуудлыг хөндөж байна.<sup>14</sup>

НҮБ-ын шинжээчид “бохирдлын голомт болон маш их бохирдолтой бүсэд амьдарч бие махбодийн болон сэтгэл зүйн эрүүл мэндээрээ хохирч, хүний эрх зөрчигдөж байгаа оршин суугчдын амьдарч байгаа газруудыг “золиосны бүс” хэмээн тодорхойлсон байна.<sup>15</sup> Энэхүү золиосны бүс нь арьс үндсээр алагчлагдсан хүн амд илүүтэй сөргөөр нөлөөлж байгааг илтгэн “арьс үндэсний золиосын бүс” хэмээн нэрлэх нь ч бий. Арьс үндсээр алагчлах үзэл, гадныхныг үл тэвчих хандлагын орчин үеийн хэлбэрүүдийн талаар өмнөх Тусгай Илтгэгч тэмдэглэхдээ: “Эдгээр золиослогдсон бүс нутгаас хамгийн их ашиг хүртэгчид нь баялгийг дэлхийн хойд бүс рүү чиглүүлдэг үндэстэн дамнасан корпорациуд, мөн үндэсний болон орон

<sup>11</sup> Union of BC Indian Chiefs, Robyn Allan: Towards Financial Responsibility in British Columbia’s Mining Industry, May 2016, pg 90

<sup>12</sup> Amnesty International Canada, A Breach of Human Rights: the human rights impacts of the Mount Polley mine disaster, May 2017

<sup>13</sup> International Seabed Authority, Exploration contracts: <https://www.isa.org.jm/exploration-contracts/>

<sup>14</sup> Amnesty International, Powering Change: Principles for Businesses and governments in the battery value chain, October 2022. ACT 30/3544/2021

<sup>15</sup> Special Rapporteur on the Issue of Human Rights Obligations Relating to the Enjoyment of a Safe, Clean, Healthy and Sustainable Environment, Supplementary information to the Report of the Special Rapporteur: Additional sacrifice zones, 2 March 2022, UN Doc. A/HRC/49/53, para. 3.

нутгийн түвшний давуу эрхтэй элитүүд юм” гэж онцолсон байдаг.<sup>16</sup> Үүнээс гадна уул уурхайн компаниуд, цахилгаан машин үйлдвэрлэгч олон улсын байгууллагууд, хэрэглэгчид болон үйлдвэрлэгчид байгаль орчны арьс үндсээр алагчлах хэлбэрийн шууд болон шууд бус үр шимийг хүртэгчид болж байна.<sup>17</sup> Иймээс өмнөх зөрчлүүд, шударга бус байдлыг дахин давтахгүйн тулд эрчим хүчний шилжилттэй холбоотой ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч компаниуд нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн бодлого, арга хэмжээг яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хүний эрхийн нийцлийг хангасан уул уурхайн үндэс нь хүний эрхийн магадлан шинжилгээ юм. Уул уурхайн салбартай холбоотойгоор хүний эрхийг хохироосон бизнесийн үйл ажиллагааны үй олон тохиолдлыг хүний эрхийн магадлан шинжилгээгээр илрүүлж, зайлсхийх боломжтой байсан. Эмнести Интернэшнл нь корпорацийн оролцогчид хүний эрхийг зөрчих, хохироохоос урьдчилан сэргийлэх, хүний эрх, байгаль орчныг хүндэтгэхийг дэмжихэд чиглэсэн хууль тогтоомжийг дэмжинэ. Сүүлийн хэдэн арван жилийн турш хүний эрхийг зөрчиж, байгаль орчны доройтуулсан олборлох үйлдвэрүүдийн үйл ажиллагаа нь нийгмийн хариуцлагын сайн дурын санаачилгууд хүний эрхийг хамгаалахад үнэхээр хангалтгүй болохыг тод харуулж байна. Мөн хууль тогтоомжууд дангаараа олборлох төслийн хүрээнд эрхийг бүрэн хамгаална гэсэн баталгаа болж чадахгүй. Гэхдээ хүний эрхийн зөрчил, хүчирхийлэл гарсан тохиолдолд хохирогчид зөрчигдсэн эрхээ зохистой сэргээх, тухайн зөрчил дахин давтагдахаас сэргийлэх баталгааг хангасан байх шаардлагатай. Улс орнууд чухал ашигт малтмалын төслийн хүрээнд хүний эрхийн зөрчил гарсан тохиолдолд хохирогчдын зөрчигдсэн эрхийг шүүхийн болон шүүхийн бус механизмаар дамжуулан сэргээх тодорхой арга хэмжээг цаг алдалгүй авах баталгааг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний шилжилтийн үед ашигт малтмалын олборлолт зайлшгүй шаардлагатай бөгөөд эрэлт нэмэгдэхийн хирээр олборлолтын хэмжээ өсөх нь тодорхой. Гэвч хүлээн авагч улс орнуудын засгийн газрууд иргэдийн цэвэр, эрүүл, тогтвортой орчинд амьдрах эрхийг хамгаалах талаар зохих арга хэмжээ аваагүйд Эмнести Интернэшнл гүнээ санаа зовниж байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсын өмнөд хэсгийн зэсийн бүсэд орших зэс, кобальтын уурхайн ойролцоо амьдарч буй иргэдийн эрүүл мэндэд нөлөөлсөн янз бүрийн сөрөг нөлөөллийг судлаачид тэдгээр аж үйлдвэрлэлийн уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй ус, хөрсний бохирдолтой холбон тайлбарладаг.<sup>18</sup> Филиппинд Эмнести Интернэшнлийн ярилцлага хийсэн никель уурхайн ойролцоо амьдардаг оршин

<sup>16</sup> Special Rapporteur on Contemporary Forms of Racism, Racial Discrimination, Xenophobia and Related Intolerance (Special Rapporteur on racism), Report: Ecological Crisis, Climate Justice and Racial Justice, 25 October 2022, UN Doc. A/77/549, para. 2

<sup>17</sup> Environmental racism describes any environmental policy, practice, law or regulation that differentially affects or disadvantages (whether intended or unintended) individuals, groups, or communities based on race, color, descent and national and ethnic origin. See: Special Rapporteur on Contemporary Forms of Racism, Racial Discrimination, Xenophobia and Related Intolerance, Ecological Crisis, Climate Justice and Racial Justice, para. 45.

<sup>18</sup> Rights and Accountability in Development (RAID UK) reported on the environmental cost of industrial copper and cobalt mines in the Democratic Republic of Congo, citing scientific studies on the impacts of industrial mining pollution on water, soil, and livelihoods, <https://raid-uk.org/wp-content/uploads/2024/03/Annexe-1-Selected-Studies.pdf>

суугчид амьсгалын замын болон арьсны өвчин, толгойн өвдөлт, шээсний замын өвчлөл, нүд загатнах зэрэг эрүүл мэндийн асуудал үүсдэг талаар мэдээлсэн байна.<sup>19</sup>

Эрчим хүчний шилжилттэй холбоотойгоор аж үйлдвэрийн олборлолт явагдаж байгаа улс орнуудын засгийн газрууд агаар, хөрс, ус болон хүнсний эх үүсвэрээс олон нийтэд нээлттэй, хараат бус байдлаар дээж авч шинжилгээ хийх, үүний үр дүнг эрсдэлийн үнэлгээ болон эрт үеийн хөндлөнгийн оролцооны төлөвлөгөөнд тусгах шаардлагатай. Хэрэв бохирдол илэрсэн тохиолдолд засгийн газрууд холбогдох компаниудаас нөхөн сэргээх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхийг шаардах ёстой.<sup>20</sup> Цаг тухайд нь дагаж мөрдөөгүй компаниуд зохих санхүүгийн болон бусад шийтгэл хүлээх ёстой.

Ашигт малтмалын олборлолтын дэлхий дахины өсөлт нь асар их хэмжээний уул уурхайн хаягдал хадгалах байгууламжуудыг зайлшгүй шаардана. Засгийн газрууд хаягдлын хадгалалтын аюулгүй байдлыг хангахын тулд шинэ арга хэмжээг хуульчлах эсвэл одоо байгаа хуулиудыг боловсронгуй болгон чанд мөрдүүлэх шаардлагатай. Тэд уурхайн хог хаягдлын байгууламжийг төлөвлөх, барьж байгуулах, ашиглахдаа өртөг зардлаас илүүтэйгээр хаягдлын хадгалалтын аюулгүй байдалд нэн тэргүүнд анхаарч, боломжит хамгийн сайн технологи, туршлагыг хэрэгжүүлэхийг компаниудаас шаардах ёстой. Түүнчлэн уурхайг өргөтгөх, хаах төлөвлөгөө, ялангуяа усны менежмент, уурхайн хог хаягдлын эрсдэлтэй холбоотой мэдээллийн ил тод байдлыг хангах, олон нийтэд нээлттэй мэдээлэх шаардлагыг компаниудад тавих нь зүйтэй.<sup>21</sup> Мөн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, зөвшөөрөл олгохдоо уур амьсгалын өөрчлөлтийн цаг уурын нөлөөллийг авч үзэхийн зэрэгцээ ил болон гүний талбайн усны түвшин, ялангуяа агуулахын ойролцоох байршлуудад онцгойлон анхаарах шаардлагатай.

Барилга байгууламжийн угсралтын ажил эхлэхийн өмнө компаниудаас бүрэн өртөг бүхий, бие даасан санхүүгийн баталгаа гаргахыг шаардах нь хаягдлын далангийн аюулгүй байдлын шилдэг технологи, сайн туршлагыг уурхайн төлөвлөлт, ашиглалт, хаалтын ажилд тусгах үр дүнтэй арга зам юм.<sup>22</sup> Энэ нь зардлыг бууруулах арга хэмжээ авахаас сэргийлэх, газар дээр нь урт хугацааны нөхөн сэргээлт хийх, хаягдлын цөөрмийн эвдрэл зэрэг байгаль орчны урьдчилан таамаглаагүй хор хөнөөлийг шийдвэрлэх санхүүгийн баталгааг хангана.<sup>23</sup>

Эрчим хүчний шилжилтийн өнөөгийн эдийн засгийн загвар нь хүний эрүүл мэнд болон байгаль эх дэлхийгээс хэт хэрэглээ, өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангахыг тэргүүнд тавьж байна. Ийм нөхцөлд түүхий эдийн шинэ эх үүсвэрийн эрэлтийг бууруулах, олборлолтын сөрөг нөлөөлөлд илүү ихээр өртөж байгаа нийгмийн бүлэгт

<sup>19</sup> Amnesty International, What do we get in return? How the Philippines nickel boom harms human rights, 9 January 2025, ASA 35/8607/2024 page 64

<sup>20</sup> Ibid page 8

<sup>21</sup> Emerman, Steven H., 2021. Bridging the Gap: Towards Best International Standards on Mine Waste Safety in British Columbia. BC Mining Law Reform and MiningWatch Canada, <https://reformbcmining.ca/reports>

<sup>22</sup> Amnesty International Canada, A Breach of Human Rights: The human rights impacts of the Mount Polley mining disaster, British Columbia, Canada, May 2017 page 14 GRID-Arendal and UN Environmental Programme report, Safety is No Accident

<sup>23</sup> Union of BC Indian Chiefs, Robyn Allan: Towards Financial Responsibility in British Columbia's Mining Industry, May 2016, pg 54

ирэх ачааллыг бууруулахын тулд нэгдсэн хүчин чармайлт шаардлагатай. Тухайлбал, автомашинаас хамааралтай улс орнууд хувийн цахилгаан автомашины батарейны хэмжээг багасгахын тулд автомашины овор хэмжээг хязгаарлаж, ашигт малтмалын эрэлтийг бууруулж болно. Түүнчлэн чулуужсан түлшээр ажилладаг автомашиныг 1:1 харьцаатай цахилгаан тээврийн хэрэгслээр солихыг чухалчлан, хүний эрхэд нийцсэн тогтвортой сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг хөдөө орон нутаг, хот, уугуул иргэдэд хүртээмжтэй, хямд нийтийн тээвэрт хөрөнгө оруулалт хийх, мөн хот суурин газарт<sup>24</sup> дугуйгаар зорчих болон явган хүний замын дэд бүтцийг сайжруулахад анхаарч хөрөнгө оруулах хэрэгтэй.<sup>25</sup>

Эрчим хүчний шударга шилжилт нь ашигт малтмалыг дахин боловсруулах шинэ арга замыг дэмжих ёстой, Тухайлбал:

- одоо байгаа батарей болон бусад эрчим хүчний шилжилтийн технологийг дахин ашиглах замаар нөөцийн үр ашигтай хэрэглээг дэмжих;
- дахин боловсруулалт нь тогтсон норм буюу хэм хэмжээ болох хүртэл улс орнуудын хүний эрхэд нийцсэн тогтвортой дахин боловсруулах компани болон хэрэглэгчдийг урамшуулах бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- солих, дахин боловсруулах, дахин ашиглаж болохуйц батарей болон бусад технологийг шаарддаг засварлах боломжтой байх” бодлогыг хэрэгжүүлэх, ингэснээр бүтээгдэхүүний ашиглалтын хугацааг уртасгаж хэт хэрэглээг бууруулах боломжтой.<sup>26</sup>

Батарейны “хог хаягдалгүй шатлалын бодлого”-ыг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай. Хэрэв сэргээгдэх эрчим хүчний технологид шилжихийн тулд эдгээр бодлого, практикт зохих хөрөнгө оруулалт, дэмжлэг үзүүлэхгүй бол түүхий эдийн хэрэглээг үр дүнтэй бууруулж чадахгүй. Засгийн газрууд, аж үйлдвэрийн салбар, хөдөлмөрийн зах зээл, олон нийт болон бизнесүүдийг **хэрэглээнд төвлөрсөн, тойрог эдийн засгийн зарчимд** зохистойгоор бэлтгэхгүйгээр дэлхий дахин эрчим хүчний шилжилттэй холбоотой ашигт малтмалын шинэ “алтны довтолгоог” даван туулахад бэрхшээлтэй байх болно.<sup>27</sup>

<sup>24</sup> The use of liquid crop-based biofuels is not a suitable response given their high human rights and environmental impacts

<sup>25</sup> Amnesty International, Stop Burning Our Rights: What governments and companies must do to protect humanity from the climate crisis, POL 30/3476/20217 June 2021

<sup>26</sup> Amnesty International, Powering Change: Principles for Businesses and governments in the battery value chain, October 2022. ACT 30/3544/2021

<sup>27</sup> GAIA, Zero waste hierarchy for batteries, Zero Waste Hierarchy for Batteries\_06 26 accessed 17 March 2025

### **3. СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ БОЛОН ЧҮХАЛ АШИГТ МАЛТМАЛЫН БҮРЭН ЭРГЭЛТ ДЭХ САНХҮҮ, ЧАДАВХ, ТЕХНОЛОГИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАЛТАД ХЭРХЭН ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ ВЭ?**

Өндөр орлоготой, их хэмжээний хүлэмжийн хий ялгаруулалттай улс орнууд чулуужсан түлшнээс үе шаттайгаар татгалзах, эсвэл сэргээгдэх эрчим хүчний дэд бүтцийг хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт олгох чиглэлд хангалттай хүчин чармайлт гаргалгүй ажиллаж ирсэн нь өнөөгийн нөхцөл байдлыг үүсгэжээ.<sup>28</sup> Уур амьсгалын сөрөг нөлөөллийг бууруулах, зайлшгүй нөлөөллийг арилгах, сургалт, дэд бүтцийг нэмэгдүүлэх, нөлөөлөлд тэргүүн эгнээнд өртөх нийгмийн бүлгүүдийг хамгаалах арга хэмжээг санхүүжүүлэхэд хөрөнгө илт дутагдаж байгааг анхаарах шаардлагатай.<sup>29</sup> НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц болон Парисын хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргээс гадна, ялангуяа өндөр орлоготой хүлэмжийн хийн ялгаруулалт өндөр улс орнууд бага орлоготой орнуудад уур амьсгалын чиглэлийн санхүүжилт олгох ёстой. Цаашлаад, өндөр орлоготой бүх улс орнууд чулуужсан түлшний үйлдвэрлэл болон түүнийг бүх салбарт ашиглахаас татгалзаж, нүүрстөрөгчгүй эдийн засагт шилжихэд шаардлагатай нөөцөөр хангах үүрэгтэй. Үүнд олон улсын тусламжийг нэмэгдүүлэх, өрийг хөнгөлөх, чөлөөлөх, татвараас зайлсхийх, зугтах асуудлыг шийдвэрлэх, сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, мөн чулуужсан түлшний татаас, хөрөнгө оруулалтаас татгалзах зэрэг арга хэмжээ орно.

Эрчим хүчний шилжилтийн үед цахилгаан дамжуулах шугам, нарны зай, салхин турбин, цэнэглэх станц, дэд станц, усан далан зэрэг шинэ дэд бүтцийг бий болгох, авто зам, нисэх онгоцны буудал, төмөр замын шугамд тохируулга, шинэчлэлт хийх шаардлагатай. Эдгээр бүтээн байгуулалтын хэрэгцээ нь зэс, бал чулуу зэрэг металл, ашигт малтмалын эрэлт хэрэгцээг эрс нэмэгдүүлнэ.<sup>30</sup> Түүнчлэн, дахин боловсруулах дэд бүтцийг өргөжүүлэх, үүнд урамшуулал олгох, цахилгаан авто машины эдэлгээ нь дууссан цахилгаан хөдөлгүүрийн батарей болон эрчим хүч хадгалах төхөөрөмжийг хүлээн авч, хүргэх, дахин боловсруулах чадавхийг тогтвортой, уялдаатай байлгахын тулд хууль эрх зүйн зохицуулалтыг нэгтгэх, олон нийтийн боловсролыг дээшлүүлэх, дахин ашиглах үйлдвэрлэлийг бий болгох шаардлагатай. Эдгээр өөрчлөлт, бүтээн байгуулалт нь их хэмжээний хөрөнгө мөнгө, цаг хугацаа шаарддаг бөгөөд ялангуяа олон улсын хууль эрх зүйн хүрээнд дэлхий нийтийн хамтын ажиллагаа дутмаг нөхцөлд асуудал улам хүндрэх эрсдэлтэй болно. Нэмж хэлэхэд, зарим

<sup>28</sup> Amnesty International, plenty to go around: Mobilizing finance for climate justice, POL 30/8850/2025 16 January 2025

<sup>29</sup> Amnesty International, Madagascar: It will be too late to help us once we are dead 26 October 2021 AFR 35/4874/2021 and A Burning Emergency: Extreme heat and the right to health in Pakistan 4 June 2023 ASA 33/6823/2023

<sup>30</sup> International Energy Agency, <https://www.iea.org/reports/global-critical-minerals-outlook-2024>, accessed 23 April 2025

корпорациуд өрсөлдөх давуу талаа ашиглан ил тод бус байдлаа зөвтгөж худалдан авалт, хамтын ажиллагааны явцад нэмэлт бэрхшээл үүсгэж байна. Өрсөлдөөнд давуу байр суурь эзлэхийн тулд ил тод бус байдлаа зөвтгөдөг корпорациудтай холбоотой оролцогчдоос худалдан авалт хийх нь дараагийн бэрхшээлтэй асуудал юм. Сэргээгдэх эрчим хүч, чухал ашигт малтмалыг дахин боловсруулах үйл явц, үйдвэрлэлийг бүрэн дүүрэн удирдан хөгжүүлэхийн тулд улс орнууд, цахилгаан машин болон технологийн компаниудын дэлхийн хэмжээний хүчин чармайлт нь хүний эрхийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай байна. Эмнести Интернэшнлийн эрхлэн гаргасан *Эрх мэдлийн өөрчлөлт: Батарей үйлдвэрлэлийн үнэлгээний сүлжээнд оролцож буй засгийн газрууд болон бизнесийн байгууллагуудад зориулсан зарчмууд* уг асуудлыг дараах зөвлөмжөөр шийдвэрлэхийг санал болгож байна:<sup>31</sup>

- Засгийн газрууд дахин ашиглах, дахин засварлах зах зээлийг хөгжүүлэхэд саад учруулж буй өмчийн эрхийн болон бусад саад бэрхшээлийг арилгаж, батарейгаар ажилладаг бүтээгдэхүүний эдэлгээний хугацааг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх, дахин ашиглах үнэ цэнийг нэмэгдүүлэхэд зохицуулалтыг идэвхитэй хэрэглэх шаардлагатай. Үүнд “засварлах боломжтой байх” бодлогын шинэчлэлийг хийж, эдэлгээний бат бэх байдлыг баталгаажуулах, шошгоны стандартыг бий болгох, бүх батарейг стандарт хэрэгслээр салгаж авах, батарейг дахин ашиглах судалгаанд хөрөнгө оруулах зэрэг арга хэмжээнүүд багтана. Мөн засгийн газрууд ашигласан цахилгаан эрчим хүчний батарейг 100% цуглуулах, кобальт, лити, никель, зэс зэрэг батарейны чухал материалуудыг нөхөн сэргээх түвшинг хамгийн багадаа 90%, түүнээс дээш хүргэх зорилтыг тавих шаардлагатай. Цаашилбал, засгийн газрууд бүрэн дахин боловсруулсан батарей руу шилжих зорилгоор хоёрдогч материалын зах зээлийг дэмжих ёстой.
- Тээвэр болон үйлдвэрлэлийн салбарыг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах шаардлага тулгарч байна. Засгийн газрууд цахилгааны сүлжээгээ 100 хувь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт яаралтай шилжүүлэх шаардлагатай бөгөөд хөгжингүй улс орнууд 2040 он гэхэд энэ зорилтод хүрэх ёстой. Мөн засгийн газрууд Ногоон Шинэ Хэлэлцээр (Green New Deal-style) загварын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, сэргээгдэх эрчим хүчний шийдлүүдэд хөрөнгө оруулалт хийхийг идэвхитэй дэмжих шаардлагатай.
- Эрүүл орчинд амьдрах эрхийг хангахын тулд: Уул уурхайн нийлүүлэлтийн сүлжээний эх шат, дахин боловсруулах төвүүдэд засгийн газрууд байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтэд үр дүнтэй хяналт тавьж, хэрэгжилтийг хангах, хууль зөрчсөн компаниудад хариуцлага тооцох ёстой. Агаарын бохирдлыг бууруулах, цэвэр, хангалттай усны нөөц, эрүүл хөрсийг хадгалах, биологийн олон янз байдлыг хамгаалах шаардлагыг тогтоож, зөрчил илэрсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх шаардлагатай.
- Батарейны технологи үйлдвэрлэгчид дахин боловсруулсан ашигт малтмалын

<sup>31</sup> Amnesty International, Powering Change: Principles for Businesses and governments in the battery value chain, October 2022. АСТ 30/3544/2021

хэрэглээг эрс нэмэгдүүлэх, батарейд агуулагдаж байгаа бүх эрдэс бодис, материалыг үр ашигтай дахин боловсруулах, эд ангиудыг энгийн, аюулгүй байдлаар салгах, дахин ашиглах зориулалттай батарейг зохион бүтээх шаардлагатай. Үйлдвэрлэл нь аюултай материалын хэрэглээг аль болох багасгаж, хэрэглэхээс зайлсхийх ёстой. Дахин боловсруулах бизнес эрхлэгчид ажилчдынхаа аюулгүй, эрүүл ажиллах нөхцлийг хангахын зэрэгцээ иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаатай хангах үүрэгтэй.

Эрүүл, аюулгүй орчинд амьдрах хүний эрхийг хүндэтгэхийн тулд улс орнууд хамтран ажиллаж, хуулийн зохицуулалт болон ял шийтгэлийн тогтолцоог уялдуулах шаардлагатай. Ингэснээр компаниуд байгаль орчны болон хөдөлмөрийн хууль тогтоомж хангалтгүй, татварын цоорхой, авлига тархсан улс орнуудад электрон хог хаягдлыг тээвэрлэх сонирхол нь багасна.<sup>32</sup>

Эх дэлхий болон хүмүүсийг тэргүүн эгнээнд тавьж, төвд нь байлгах цогц хандлага бидэнд шаардлагатай байна. Эрчим хүчний шилжилтийн үеийн ашигт малтмалыг олж авах, түүнд хяналтаа тогтоох дэлхийн хэмжээний өрсөлдөөнд бусад улс үндэстнүүдээс давуу байдлыг олж авах, эсвэл дотоодын аж ахуйн нэгжийн зах зээлд эзлэх хувийг нэмэгдүүлэхийн тулд улс орнууд ашигт малтмалын хөгжүүлэлтийг түргэвчлэх,<sup>33</sup> эсхүл хүний эрх, байгаль орчны магадлан шинжилгээг хуульчлах хүчин чармайлтыг багасгахыг оролддог.<sup>34</sup> Хүний эрхийг үл тоомсорлож, дэлхийн металл, ашигт малтмалын зах зээлийн өсөлтийг хурдасгаснаар аливаа улс орон, компани болон хөрөнгө оруулагчид эрчим хүчний шилжилтийн ашигт малтмалын олборлолттой холбоотой хор уршгаас урьдчилан сэргийлэх, арилгах олон улсын үүрэг амлалтаас ухрах эрсдэлтэй. Эдгээр яаралтай өөрчлөлтүүдийг хийх боломж улам бүр хумигдаж байна.

<sup>32</sup> Amnesty International, Injustice Incorporated, Advancing the Rights to Remedy for Corporate Abuses of Human Rights, 2014, pages 191-192

<sup>33</sup> Canada, Privy Council Office statement, 1 February 2024, <https://www.canada.ca/en/privy-council/news/2024/02/chair-of-ministerial-working-group-on-regulatory-efficiency-for-clean-growth-projects-issues-statement.html>, and USA Presidential Executive Order Immediate Measures to Increase America Mineral Production, 20 March 2025

<sup>34</sup> Joint Civil Society Statement reacting to lack of majority in COREPER on CSDDD, 28 February 2025, <https://www.amnesty.eu/news/european-union-joint-civil-society-statement-reacting-to-lack-of-majority-in-coreper-on-csddd/>

**Эмнести Интернэшнл бол хүн бүрд эрхийг нь эдлүүлэхийн төлөө хүмүүсийн хүнлэг сэтгэлд тулгуурлан кампанит ажил өрнүүлдэг 10 сая хүнийг эгнээндээ нэгтгэсэн даян дэлхийн хүний эрх хамгаалагчдын хөдөлгөөн юм.**

**Эрх мэдэлтнүүд олон улсын эрх зүйг хүндэтгэж, үүрэг амлалтаа биелүүлдэг, хариуцлага хүлээдэг дэлхий ертөнцийг бий болгох нь бидний зорилго.**

**Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл, эдийн засгийн ашиг сонирхол, шашны үзлээс хараат бус бөгөөд гишүүд, дэмжигчдийн хандив, дэмжлэгээр санхүүждэг.**

**Эв санааны нэгдэл, энэрэнгүй хүмүүсийн үйлдэл нь илүү сайхан нийгмийн төлөөх өөрчлөлтийг бий болгож чадна хэмээн бид итгэдэг.**

**Contact**

  
[info@amnesty.org](mailto:info@amnesty.org)

  
[facebook.com/  
AmnestyGlobal](https://facebook.com/AmnestyGlobal)

  
[@Amnesty](https://twitter.com/Amnesty)

  
[amnesty.org](https://amnesty.org)



Amnesty International  
Peter Benenson House  
1 Easton Street  
London WC1X 0DW, UK

Өөрөөр заагаагүй бол энэхүү баримт бичигт агуулагдах контентыг Creative Commons (атрибут, арилжааны бус, олон улсын 4.0) лицензийн эрхээр хамгаалсан. ([creativecommons.org/licenses/by-nc-nd/4.0/legalcode](https://creativecommons.org/licenses/by-nc-nd/4.0/legalcode)-г үзнэ үү)

Хэрэв материал нь Эмнести Интернэшнлээс өөр зохиогчийн эрх эзэмшигчтэй холбоотой бол энэ материал нь Creative Commons лицензэд хамаарахгүй.

Дэлгэрэнгүй мэдээллийг Эмнести Интернэшнлийн вэб сайтын зөвшөөрлийн хуудаснаас авна уу.

Индекс: **IOR 40/9263/2025**

Хэвлэл: 2025 оны 4 сар

Эх хэл: Англи

© Amnesty International 2025